


## ХАЯГИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ (ADDRESS.GAZAR.GOV.MN)-ИЙН ТУХАЙ

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 181 дүгээр тогтоолоор “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”-д өөрчлөлт оруулж, мөн Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2022 оны С/41 дүгээр тушаалаар “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага MNS5283:2022 стандарт”-ыг шинэчлэн баталсан.

Шинэчилсэн хаягийг цаашид мөрдөж ажиллах зорилгоор хаягийн мэдээллийн нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлж, 37,401 гудамж, 222,195 зам, 258,650 газар, усны нэр, 628,436 орц, гарцыг мэдээллийн санд хөрвүүлэн, 202,159 барилга, 767,519 нэгж талбар, өвөлжөө, хаваржаа, газар тариалангийн газрын нэгж талбарт хаяг олгоод байна.



2024 онд Олон улсын жишигт нийцсэн хаягийн мэдээллийн системийн шинэ хувилбарыг хаягийн удирдлагын систем, иргэд олон нийтэд нээлттэй цахим гэсэн 2 төрлөөр хөгжүүлэн, нийслэлийн хэмжээнд 527,774 орц гарц, 59,236 гудамж, 64,021 замын мэдээллийг боловсруулж, цахим системд хөрвүүлэн оруулснаар 439,050 нэгж талбар, 219,329 барилгад шинэчилсэн хаяг олгоод байна. Хаягийн нээлттэй цахим системээр дамжуулан иргэд олон нийт нэгж талбар, барилга, байгууламжийн хаягийн тодорхойлолт, хаягийн түүхчилсэн лавлагааг ДАН танилт нэвтрүүлэлтийн системээр дамжин авах боломж бүрдсэн.

Иргэн, хуулийн этгээд нь хаягийн мэдээллийн нэгдсэн систем (address.gazar.gov.mn)-ээр дамжуулан дараах үйлчилгээг авах боломжтой.

- 1 Нэгж талбарын хаягийн тодорхойлолт
- 2 Нэгж талбарын түүхчилсэн лавлагаа
- 3 Барилга, байгууламжийн хаягийн тодорхойлолт

## 4 Барилга, байгууламжийн хаягийн түүхчилсэн лавлагаа

### Үйлчилгээний төрөл




БАРИЛГЫН ХАЯГИЙН  
ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАГАА

Үйлчилгээ авах



НЭГЖ ТАЛБАРЫН ХАЯГИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ

Үйлчилгээ авах



БАРИЛГЫН ХАЯГИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ

Үйлчилгээ авах



НЭГЖ ТАЛБАРЫН ХАЯГИЙН  
ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАГАА

Үйлчилгээ авах

#### ХОЛБОО БАРИХ

1900-0101

info@gazar.gov.mn

Засгийн газрын 12-р байр 15170 Барилгачдын талбай 3 Улаанбаатар хот

#### ЧУХАЛ ХОЛБООСУУД

Түгээмэл асуулт

Статистик мэдээлэл

Веб сайт